**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/867 Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Магсаржав баг 1 дүгээр гудамжны 15 тоотод байрлах Очирпүрэвийн Мягмардорж /ХМ86112505/-ийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 640.0 метр квадрат газрыг хаягийн мэдээллийн сангийн дагуу 752.0 метр квадрат болгон 7 жилийн хугацаагаар,

2.Жаргалант сумын Цамбагарав баг Занын 1 дүгээр гудамжны 117 тоотод байрлах Ховд аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо /9068171/-ийн албан хэрэгцээний зориулалттай 1655.0 метр квадрат газрыг хаягийн мэдээллийн сангийн дагуу 1644.0 метр квадрат болгон 6 жилийн хугацаагаар,

3.Жаргалант сумын Цамбагарав баг Заны 1 дүгээр гудамжны 108 тоотод байрлах Ховд аймгийн Прокурорын газар /9066438/-ийн төрийн захиргааны байгууллагын зориулалттай 1199.0 метр квадрат газрыг хаягийн мэдээллийн сангийн дагуу 2828.0 метр квадрат болгон 6 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

4.Эзэмшил газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа иргэн, аж ахуйн нэгжид газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

5.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуйн нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ